



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 238

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2016 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 172 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Стандарт инвестмент ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Стандарт инвестмент ҮЦК" ХХК /Ч.Жаргал/-д анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР